**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 17 өдөр | Дугаар 142 | Улаанбаатар хот

Дотоод аудитын газрын ажлыг дүгнэх,
төлөвлөгөө батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.23, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дотоод аудитын газрын 2021 оны ажлыг "Хангалттай" үнэлгээтэйгээр дүгнэсүгэй.

2. Дотоод аудитын газрын 2022 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. 2022 оны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод аудитын газар (Ч.Цоодол)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга (А.Тлейхан)-д даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ Э.САМДАН

220010384

*Эрчим хүчний зохицуулах хорооны*
*2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн*
*142 дугаар тогтоолын хавсралт*

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийгдэх ажлууд | Хийгдэж дуусах хугацаа | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| 1. | Хорооны 2021 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх; | I улирал | 2021 оны 01 тоот тушаалын биелэлтийг дүгнэн холбогдох зөвлөмж гаргасан байна. |
| 2. | Тусгай зөвшөөрлийн зохицуулалтад аудит хийх; (Цахилгаан түгээх хангах -1, Дулаан түгээх, хангах 1 компани дээр хийх) | II улирал | Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна. |
| 3. | Хэрэглэгчийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд түүвэрчилсэн байдлаар аудит хийх; | III улирал | Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна. |
| 4. | Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг хянасан байдалд аудит хийх (Дулаан түгээх, хангах -2 компани дээр хийх) | Жилдээ | Аудит хийгдэж, зөвлөмж гарсан байна. |
| 5. | Эрчим хүч хэмнэлтийн газрын чиг үүргийн биелэлтийн байдалд аудит хийх; | Жилдээ | Аудит хийгдэж, зөвлөмж гарсан байна. |
| 6. | Холбогдох байгууллагаас Хороонд өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд болон Үндэсний аудитын газар (ҮАГ)-ын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих; | Жилдээ | Зөвлөмжийн биелэлтийг хангах чиглэлд ажлууд хийгдсэн байна. |
| 7. | Хорооны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх; | Жилдээ | Аудит хийгдэж, зөвлөмж гарсан байна. |
| 8. | Хорооны Зохицуулагчдын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Хорооны тогтоолын биелэлт болон тусгайлан явуулах бусад аудит, судалгаа хийх; | Жилдээ | Тухайн чиглэлээр аудит хийгдэж холбогдох дүгнэлт, зөвлөмж гарсан байна. |